

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГAA-2026/138/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)4	
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр).....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр).....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв (төгрөгөөр)	8
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан -Орон нутгийн төсөв (төгрөгөөр)	11
Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
3.1 Залруулсан алдаа:.....	11
3.3 Зөвлөмж	13
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 12

№

41

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвөөс байгууллагын тогтмол зардлын 70.0 хувь буюу 1,694,877.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталснаас шалтгаалан байр ашиглалттай холбоотой 989,823.0 мянган төгрөгийн өр үүссэн байна.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 15,389,605.7 мянган төгрөгийг нэхэмжилснээс 14,683,885.9 мянган төгрөгийг авч, 705,719.8 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж, орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Нийт хасагдлын 60.7 хувь 428,380.3 мянган төгрөг нь программын, 14.5 хувь 102,278.7 мянган төгрөг нь эмч байцаагчийн, 24.8 хувь 170,233.8 мянган төгрөг нь олонлогийн хасагдал гэсэн тооцоолол гаргасан байна.

Аудитын гол асуудал

Тайланд онд төсвөөс 1,457,696.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 3,200,302.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 795,529.1 мянган төгрөгийн эмнэлгийн барилгыг хүлээн авсан байна.

822505000107

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 26-ны А/93 дугаар тушаалаар Азийн хөгжлийн банк, ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" Мон- 9218 төслийн хүрээнд 3,145,281.5 мянган төгрөгийн үнэ бүхий тусгай зориулалтын бүрэн тоноглогдсон 2 автомашин, тоног төхөөрөмжийн хамт хүлээлэн өгсөн байна.

Вакум мэс заслын өрөөний засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх 1,391,046.8 мянган төгрөгийн ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Үйлдвэрчний эвлэлийн санаачилгаар эмнэлэг, албадууд хамтран 14,800.0 мянган төгрөгөөр 1 өрөөг тохижуулан сургалтын өрөөтэй болсон байна.

Бусад асуудал

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 чиг үүрэг, 12 зорилтын хүрээнд 139 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 65 арга хэмжээ 100.0 хувь, 30 арга хэмжээг 90.0-99.0 хувь, 37 арга хэмжээг 70.0-90.0 хувь, 7 арга хэмжээг 50.0-59.0 хувьтай хэрэгжүүлж, нийт дүнгээр 92.3 хувиар биелэлтийг гарган байгууллагын удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,447,774,918.00	2,804,732,791.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	65,625,215.61	80,883,843.56
312	Банканд байгаа бэлэн мөнгө	65,625,215.61	80,883,843.56
3121	Төгрөг	65,625,215.61	80,883,843.56
31211	Төрийн сангийн харилцах	65,625,215.61	80,883,843.56
33	АВЛАГА	1,787,850,965.52	1,476,107,217.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	700,411.00	2,009,486.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,752,591,221.30	1,452,091,618.75
335	Бусад авлага	34,559,333.22	22,006,112.31
3351	Байгууллагаас авах авлага	23,426,570.00	20,179,449.09
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,132,763.22	1,826,663.22
34	УРЬДЧИЛГАА	429,314,050.00	8,912,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	429,314,050.00	8,912,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,164,984,686.87	1,238,829,230.71
351	Түүхий эд материал	638,825,193.20	717,618,578.69
35110	Тусгай зориулалттай материал	136,079,764.00	240,722,593.65
35130	Эм боох материал	502,745,429.20	476,895,985.04
354	Хангамжийн материал	526,159,493.67	521,210,652.02
35410	Бичиг хэргийн материал	12,196,130.00	8,334,400.00
35420	Аж ахуйн материал	33,737,640.95	23,462,022.64
35440	Түлш, шатах тослох материал	3,797,685.81	3,862,161.68
35450	Барилгын засварын материал	4,720,000.00	6,848,700.00
35460	Хүнсний материал	6,798,750.00	5,144,250.00
35470	Бусад хангамжийн материал	464,909,286.91	473,559,117.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,619,438,881.13	27,285,451,701.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,619,438,881.13	27,285,451,701.12
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	26,185,121,270.00	26,857,082,288.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,258,113,658.14	22,058,642,814.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,994,190,927.20)	(3,711,723,647.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,179,845,343.80	3,108,978,343.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(406,801,469.26)	(362,301,469.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,170,515,458.29	12,786,660,212.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,443,446,453.87)	(7,401,701,070.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	711,930,642.55	731,281,027.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	(290,844,982.45)	(352,753,921.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,508,500.00	880,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,508,500.00)	(880,000.00)
393	Биет бус хөрөнгө	434,317,611.13	428,369,413.07
39301	Программ хангамж	34,756,622.00	34,756,622.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(19,039,010.87)	(24,987,208.93)
39303	Бусад биет бус хөрөнгө	418,600,000.00	418,600,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	30,067,213,799.13	30,090,184,492.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	993,283,529.05	1,771,104,583.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	993,283,529.05	1,771,104,583.02
413	Өглөг	993,283,529.05	1,771,104,583.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,939,089.50	3,454,083.16
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	967,396,740.22	1,661,860,478.50
4136	Бусад өглөг	14,947,699.33	105,790,021.36
41361	Байгууллагад төлөх өглөг	14,284,838.13	91,752,582.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	662,861.20	14,037,439.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	29,073,930,270.08	28,319,079,909.43
51	Засгийн газрын хувь оролцоо	29,073,930,270.08	28,319,079,909.43

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,279,908,710.20	8,279,908,710.20
51101	Өмч: - төрийн	8,279,908,710.20	8,279,908,710.20
512	Хуримтлагдсан үр дүн	16,965,680,951.60	16,210,830,590.95
51210	Өмнөх үеийн үр дүн	16,965,680,951.60	16,965,680,951.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	(754,850,360.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,828,340,608.28	3,828,340,608.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>30,067,213,799.13</u>	<u>30,090,184,492.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24,956,535,880.88	20,128,127,633.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,919,426,782.88	3,749,364,217.23
120	Нийтлэг татварын бус орлого	9,919,426,782.88	3,749,364,217.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,819,178.00	383,650,356.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	380,222,290.00	353,503,232.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,596,888.00	30,147,124.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,526,607,604.88	3,365,713,861.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,037,109,098.00	16,378,763,416.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,032,009,400.00	1,694,877,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,032,009,400.00	1,694,877,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,005,099,698.00	14,683,885,916.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,005,099,698.00	14,683,885,916.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,520,855,018.13	20,837,200,561.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,520,855,018.13	20,837,200,561.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,509,946,318.13	20,787,623,633.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,220,639,161.50	9,637,177,268.12
210101	Үндсэн цалин	4,864,387,887.05	5,482,681,650.73
210102	Нэмэгдэл	2,462,346,761.61	2,662,096,964.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	319,212,321.37	684,580,120.00
210104	Урамшуулал	574,692,191.47	807,818,533.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,049,162,764.31	1,234,819,250.91
210201	Тэтгэврийн даатгал	709,550,861.05	831,657,750.91
210202	Тэтгэмжийн даатгал	84,982,251.40	100,790,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,426,800.00	50,395,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	42,426,800.00	50,395,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	169,776,051.86	201,580,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,866,652,890.81	1,848,857,042.34
210301	Гэрэл, цахилгаан	117,970,185.32	166,714,344.04
210302	Түлш, халаалт	986,008,705.49	1,163,559,270.30
210303	Цэвэр, бохир ус	762,674,000.00	518,583,428.00
2104	Хангамж, бараа материалын зардал	802,530,973.71	437,252,915.52
210401	Бичиг хэрэг	28,460,755.00	27,427,005.00
210402	Тээвэр, шатахуун	143,338,255.32	192,392,891.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,364,070.40	26,137,852.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,377,140.05	25,088,203.85

**Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	83,128,190.00	121,611,654.46
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	378,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	497,484,562.94	44,595,308.71
2105	Нормативт зардал	3,135,920,907.33	3,322,154,435.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,833,521,597.33	3,031,440,635.50
210502	Хоол, хүнс	280,435,260.00	279,618,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,964,050.00	11,095,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,223,252.00	132,692,640.00
210604	Урсгал засвар	83,223,252.00	132,692,640.00
2107	Томилолт, зочны зардал	39,137,500.00	44,739,100.00
210702	Дотоод албан томилолт	39,137,500.00	44,739,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,616,848.00	183,721,788.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,991,128.00	169,016,310.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,452,000.00	2,576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,485,800.00	3,913,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	449,100.00	657,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	332,772.00	374,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,867,000.00	-
210807	Газрын төлбөр	3,325,970.00	2,094,020.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	110,768.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,602,310.00	5,090,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,280,062,020.47	3,946,208,993.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,280,062,020.47	3,946,208,993.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,908,700.00	49,576,927.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,908,700.00	49,576,927.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,147,124.67
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,908,700.00	19,429,803.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,435,680,862.75</u>	<u>(709,072,928.37)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	45,777,432.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	45,777,432.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(45,777,432.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,435,680,862.75</u>	<u>(754,850,360.65)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>15,032,297,745.70</u>	<u>17,063,123,801.55</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	383,824,818.00	383,860,783.00
120	Нийтлэг татварын бус орлого	383,824,818.00	383,860,783.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	383,824,818.00	383,860,783.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	371,227,930.00	353,713,659.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,596,888.00	30,147,124.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,648,472,927.70	16,679,263,018.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,032,009,400.00	1,694,877,500.00

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,032,009,400.00	1,694,877,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,616,463,527.70	14,984,385,518.55
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,616,463,527.70	14,984,385,518.55
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	15,415,832,301.98	16,048,229,294.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,415,832,301.98	16,048,229,294.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,402,185,041.98	15,998,652,366.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,198,823,996.45	9,645,539,599.10
210101	Үндсэн цалин	4,506,473,118.27	5,201,705,863.84
210102	Нэмэгдэл	2,745,230,376.68	2,828,109,361.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	381,801,800.00	683,725,374.14
210104	Урамшуулал	565,318,701.50	931,999,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,060,670,500.00	1,235,145,700.00
210201	Тэтгэврийн даатгал	721,256,000.00	831,984,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	84,853,600.00	100,790,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,426,800.00	50,395,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	42,426,800.00	50,395,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	169,707,300.00	201,580,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,740,644,047.44	1,693,677,500.00
210301	Гэрэл, цахилгаан	115,080,729.89	149,399,999.84
210302	Түлш, халаалт	926,193,609.55	1,055,686,018.43
210303	Цэвэр, бохир ус	699,369,708.00	488,591,481.73
2104	Хангамж, бараа материалын зардал	321,867,315.87	354,031,800.00
210401	Бичиг хэрэг	24,676,375.00	20,157,386.00
210402	Тээвэр, шатахуун	146,593,102.00	195,848,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,422,248.87	25,982,114.00
210404	Ном, хэвлэл	1.00	180,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,820,000.00	11,334,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	125,355,590.00	100,529,300.00
2105	Нормативт зардал	3,463,591,530.22	2,695,161,089.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,125,780,991.42	2,431,431,378.63
210502	Хоол, хүнс	303,823,738.80	232,089,711.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,986,800.00	31,640,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	530,907,264.00	156,238,740.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,404,864.00	18,120,800.00
210604	Урсгал засвар	90,502,400.00	138,117,940.00
2107	Томилолт, зочны зардал	44,700,100.00	32,986,100.00
210702	Дотоод албан томилолт	44,700,100.00	32,986,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,980,288.00	185,871,838.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,340,628.00	168,656,710.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,452,000.00	2,576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,485,800.00	3,913,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	449,100.00	657,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	332,772.00	374,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,867,000.00	-
210807	Газрын төлбөр	3,325,970.00	2,094,020.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	110,768.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,616,250.00	7,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,647,260.00	49,576,927.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,647,260.00	49,576,927.67

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	30,147,124.67
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,647,260.00	19,429,803.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(383,534,556.28)</u>	<u>1,014,894,506.95</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,399,900.00	999,635,879.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,399,900.00	999,635,879.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,399,900.00	999,635,879.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,399,900.00	999,635,879.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(29,399,900.00)</u>	<u>(999,635,879.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(412,934,456.28)	15,258,627.95
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	478,559,671.89	65,625,215.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,391,415.61	80,883,843.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	9,530,000,088.85	21,638,249,407.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	9,530,000,088.85	21,638,249,407.33
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	7,435,680,862.75	7,435,680,862.75
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	16,965,680,951.60	29,073,930,270.08
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	16,965,680,951.60	29,073,930,270.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	16,965,680,951.60	29,073,930,270.08
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(754,850,360.65)	(754,850,360.65)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,279,908,710.20	3,828,340,608.28	16,210,830,590.95	28,319,079,909.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,918,816,800.00	15,352,987,673.60	565,829,126.40	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,918,816,800.00	14,353,351,794.6	1,565,465,005.4	90.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,520,358,300.00	14,303,774,866.93	1,216,583,433.1	92.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,646,776,200.00	9,645,539,599.10	1,236,600.9	100.0

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210101	Үндсэн цалин	5,409,314,900.00	5,201,705,863.84	207,609,036.2	96.2
210102	Нэмэгдэл	2,894,400,600.00	2,828,109,361.12	66,291,238.9	97.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	411,061,700.00	683,725,374.14	(272,663,674.1)	166.3
210104	Урамшуулал	931,999,000.00	931,999,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,235,145,700.00	1,235,145,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	831,984,200.00	831,984,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	100,790,400.00	100,790,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,395,200.00	50,395,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	50,395,200.00	50,395,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	201,580,700.00	201,580,700.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	354,507,000.00	354,031,800.00	475,200.0	99.9
210401	Бичиг хэрэг	25,000,000.00	20,157,386.00	4,842,614.0	80.6
210402	Тээвэр, шатахуун	161,000,000.00	195,848,500.00	(34,848,500.0)	121.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,827,000.00	25,982,114.00	(3,155,114.0)	113.8
210404	Ном, хэвлэл	180,000.00	180,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000,000.00	11,334,500.00	38,665,500.0	22.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	95,500,000.00	100,529,300.00	(5,029,300.0)	105.3
2105	Нормативт зардал	2,699,570,300.00	2,695,161,089.83	4,409,210.2	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,481,570,300.00	2,431,431,378.63	50,138,921.4	98.0
210502	Хоол, хүнс	150,000,000.00	232,089,711.20	(82,089,711.2)	154.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	68,000,000.00	31,640,000.00	36,360,000.0	46.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,269,461,300.00	155,038,740.00	1,114,422,560.0	12.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,111,663,600.00	18,120,800.00	1,093,542,800.0	1.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,320,000.00	-	7,320,000.0	-
210604	Урсгал засвар	150,477,700.00	136,917,940.00	13,559,760.0	91.0
2107	Томилолт, зочны зардал	33,000,000.00	32,986,100.00	13,900.0	100.0
210702	Дотоод албан томилолт	33,000,000.00	32,986,100.00	13,900.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	281,897,800.00	185,871,838.00	96,025,962.0	65.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,728,800.00	168,656,710.00	84,072,090.0	66.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,452,000.00	2,576,000.00	4,876,000.0	34.6
210803	Даатгалын үйлчилгээ	3,913,500.00	3,913,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,303,500.00	657,608.00	645,892.0	50.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	374,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	3,526,000.00	2,094,020.00	1,431,980.0	59.4

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,000,000.00	-	5,000,000.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,600,000.00	7,600,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,458,500.00	49,576,927.67	348,881,572.33	12.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	398,458,500.00	49,576,927.67	348,881,572.3	12.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	193,562,400.00	30,147,124.67	163,415,275.3	15.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	171,882,000.00	-	171,882,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,014,100.00	19,429,803.00	13,584,297.0	58.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	999,635,879.00	(999,635,879.0)	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	999,635,879.00	(999,635,879.0)	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	999,635,879.00	(999,635,879.0)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,917,616,800.00	15,368,246,301.55	549,370,498.5	96.5
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,024,546,100.00	14,984,385,518.6	40,160,581.5	99.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,024,546,100.00	14,984,385,518.55	40,160,581.5	99.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	893,070,700.00	383,860,783.00	509,209,917.0	43.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	827,445,400.00	353,713,659.00	473,731,741.0	42.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,147,124.00	(30,147,124.0)	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	65,625,300.00	-	65,625,300.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,625,215.61	65,625,215.61	-	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,425,215.61	80,883,843.56	(16,458,627.9)	125.5

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан -Орон нутгийн төсөв (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,694,877,500.00	1,694,877,500.00	0.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,694,877,500.00	1,694,877,500.0	0.0	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,694,877,500.00	1,694,877,500.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,693,677,500.00	1,693,677,500.00	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	149,400,000.00	149,399,999.84	0.2	100.0
210302	Түлш, халаалт	1,184,277,500.00	1,055,686,018.43	128,591,481.6	89.1
210303	Цэвэр, бохир ус	360,000,000.00	488,591,481.73	(128,591,481.7)	135.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,694,877,500.00	1,694,877,500.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,694,877,500.00	1,694,877,500.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,694,877,500.00	1,694,877,500.00	-	100.0

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,930,616.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд үндсэн цалингийн зардлыг 12,418.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 994.0 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлын 2,653.3 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 296.0 мянган төгрөгөөр дутуу, бичиг хэргийн зардлыг 580.0 мянган төгрөгөөр, эмийн зардлыг 138.0 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,633.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 8,765.5 мянган төгрөгөөр, бараа материал акталсны зардлыг 2,653.3 мянган төгрөгөөр тус тус илүү,
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 933,677.3 мянган төгрөгөөр дутуу, багаж, техник, хэрэгслийн зардлыг 927,677.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасныг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 56,682,134.3 мянган төгрөгийн 512 мэдээллээс, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингаас бусад 5 саяас дээш орлогын гүйлгээ нийт 2,980,873.8 мянган төгрөгийн 23 мэдээллийг тус тус мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 201,157.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 201,157.3 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

Нэг. Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Улсын хоёрдугаар төв эмнэлэгтэй холбоотой 19,853.0 мянган төгрөгийн, шүүхийн шийдвэрийн буруутай этгээдээр төлүүлэх 1,183.5 мянган төгрөгийн, хувь хүмүүс, ажиллагсадтай холбоотой 2,652.6 мянган төгрөгийн авлага тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилган, бууруулах албан шаардлага хүргүүлсэн.

Хоёр. Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт захиалагчийн хяналтын зардлын өр 16,227.3 мянган төгрөгийн, хувь хүмүүс, ажиллагсадтай холбоотой 12,112.6 мянган төгрөгийн өглөг тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, бууруулах албан шаардлага хүргүүлсэн.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний тасгийн их эмчийн амралтын цалинг 1,040.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

Хоёр. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 31,120.7 мянган төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Ангилал шинэчлэн батлах тухай" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт зохицуулалт хийхдээ харьяалагдах дээд шатны төсөв захирагчид саналаа хүргүүлэн, зөвшөөрөл авсны үндсэн дээр баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэж байх.

Илрүүлэлт: Тайлант онд 14,688.6 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэгүүрт байршсан барааг өөр этгээдээс худалдан авахгүй байх.

Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 705,719.8 мянган төгрөг хасагдсан, хасагдлын дүн буураагүй, эмч эмнэлгийн ажилтнаас шалтгаалсан 102,278.7 мянган төгрөгийн хасагдал байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1.даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"; 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн заалттай

нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрүүл мэндийн даатгалын газраас нэхэмжилсэн дүнгээс эмч, эмнэлгийн ажилтны буруугаас шалтгаалсан хасагдлын дүнг бууруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлж байгууллага санхүүгийн хувьд тогтвортой, үр ашигтай ажиллахад чиглэсэн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	Үр дүнгийн тайланд үндсэн цалингийн зардлыг 12,418.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 994.0 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлын 2,653.3 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 296.0 мянган төгрөгөөр дутуу, бичиг хэргийн зардлыг 580.0 мянган төгрөгөөр, эмийн зардлыг 138.0 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,633.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 8,765.5 мянган төгрөгөөр, бараа материал акталсны зардлыг 2,653.3 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	1	16,065.8	-	-	1	16,065.8	1	16,065.8	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 933,677.3 мянган төгрөгөөр дутуу, багаж хэрэгслийн зардлыг 927,677.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	933,677.3	-	-	1	933,677.3	1	933,677.3	-	-	-	-
	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 56,682,134.3 мянган төгрөгийн 512 мэдээллээс, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингаас бусад 5 саяас дээш орлогын гүйлгээ нийт 2,980,873.8 мянган төгрөгийн 23 мэдээллийг мэдээлээгүй.	1	2,980,873.8	1	2,980,873.8	-	-	1	2,980,873.8	-	-	-	-
Дүн		3	3,930,616.9	1	2,980,873.8	2	949,743.1	3	3,930,616.9	-	-	-	-

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний тасгийн их эмчийн амралтын цалинг 1,040.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон.	1	1,040.3	-	-	-	-	1	1,040.3	-	-
	Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Улсын Хоёрдугаар төв эмнэлэгтэй холбоотой 19,853.0 мянган төгрөгийн, шүүхийн шийдвэрийн буруутай этгээдээр төлүүлэх 1,183.5 мянган төгрөгийн, хувь хүмүүс, ажиллагсадтай холбоотой 2,652.6 мянган төгрөгийн авлага тусгасан.	1	23,689.1	-	-	1	23,689.1	-	-	-	-
	Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт захиалагчийн хяналтын зардлын өр 16,227.3 мянган төгрөгийн, хувь хүмүүс, ажиллагсадтай холбоотой 12,112.6 мянган төгрөгийн өглөг тусгасан.	1	28,339.9	-	-	1	28,339.9	-	-	-	-
	Тайлант онд 14,688.6 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	14,688.6	-	-	-	-	1	14,688.6	-	-
	Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 31,120.7 мянган төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулсан.	1	31,120.7	-	-	-	-	1	31,120.7	-	-
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар	1	102,278.7	-	-	-	-	1	102,278.7	-	-

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	705,719.8 мянган төгрөг хасагдсан, хасагдлын дүн буураагүй, эмч эмнэлгийн ажилтнаас шалтгаалсан 102,278.7 мянган төгрөгийн хасагдал байна.										
Дүн		6	201,157.3	-	-	2	50,029.0	4	149,128.3	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			